



**МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ**

Засгийн газрын XIV байр, Чингисийн өргөн чөлөө,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17060
Утас: 26 30 51, Факс: (976) 7004 3479,
Цахим шуудан: info@energy.gov.mn

2024.07.05 № 8/2095

танай _____-ны № _____-т

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ КОМПАНИУДАД

Эрчим хүчний яамнаас зарласан “Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн оргил ачаалалд ажиллах тархмал дулааны эх үүсвэр /Улаанбаатар/” төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт оролцохоор сонирхож буй компаниас 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдөр ирүүлсэн тодруулга асуултын хариултыг хавсралтаар хүргүүлж байна.


Хавсралт 3 хуудастай

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА  Н.ТАВИНБЭХ



170600001762

Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... тоот албан бичгийн хавсралт



“УЛААНБААТАР ХОТЫН ТӨВЛӨРСӨН ДУЛААН ХАНГАМЖИЙН СИСТЕМИЙН ОРГИЛ АЧААЛАЛД АЖИЛЛАХ ТАРХМАЛ ДУЛААНЫ ЭХ ҮҮСВЭР /УЛААНБААТАР/” ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ

2024.07.02 -НД ИРҮҮЛСЭН ТОДРУУЛГЫН ХАРИУ:

1. Тендерийн 1-р шатанд зөвхөн техникийн шийдэл болон саналаа өгнө, ямарваа нэг ажил гүйцэтгэх төсөв өгөхгүй гэж ойлгосон. Энэ зөв үү?

Хариулт: Зөв.

2. Түлхүүр гардуулах нөхцөл үү, энэ талаар ямар нэгэн мэдээлэл алга байна.

Хариулт: Тендерт шалгарсан гүйцэтгэгч ажлын даалгаврын дагуу НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ төслийг гүйцэтгэж, тоног төхөөрөмжийг нийлүүлэн барилга угсралтын ажлыг гүйцэтгэн, ашиглалтад хүлээлгэн өгнө.

3. ТШЗ 19.1 Техникийн чадавхи болон туршлагын шаардлага. Хэрэв хийн дулааны станц барих гэж байгаа бол хийн хангамжийн угсралт, суурилуулалтын чиглэлийн инженер 2-аас багагүй байх шаардлагатай. Мөн ашиглалтын чиглэлийн 2-оос доошгүй инженерүүд байх шаардлагатай. Дээрх инженерүүдийн аль нэг нь мэргэшсэн зэрэгтэй байх гэх мэт шаардлагууд ТШЗ дээр тавигдахгүй байсан уу?

Хариулт: Үгүй.

4. ТШЗ 19.4-т 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна. Гэтэл өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.3-т Түншлэл болон туслан гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэх ажил үүргийн дагуу тусгай зөвшөөрөлтэй байна. Эдгээр заалтууд хоорондоо зөрчилдөөд байна. Үүнийг түншлэлийн гишүүд ТШЗ 19.3-т заасан тусгай зөвшөөрлүүдийг хамтдаа хангасан байж болно гэж ойлголоо. Ингэж ойлгох нь зөв үү, тодруулга өгнө үү.

Хариулт: Зөрчилдөөгүй. ТШЗ 19.3-т заасны дагуу Түншлэл болон туслан гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэх ажил үүргийн дагуу тусгай зөвшөөрөлтэй байна.

ТШЗ 19.4-т 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

5. ТШЗ 19.3 Тусгай зөвшөөрөл. Хийн дулааны станц барих гэж байгаа бол хийн хангамжийн тусгай зөвшөөрлүүд зайлшгүй шаардлагатай. Энэ тусгай зөвшөөрлүүдийг яагаад оруулаагүй вэ?

Хариулт: Тус ажил нь 112 МВт-ийн дулааны станцын эх үүсвэр барих ажил тул Эрчим хүчний яамнаас олгодог холбогдох тусгай зөвшөөрлийг зааж өгсөн. Мөн ажиллах хүчний шаардлага дээр тухайн холбогдох ажиллах хүчний хүний нөөцийн мэдээллийг тусгасан.

6. Мөн тухайн ажлын зураг төслийг хамтад нь боловсруулах асуудал яригдаж байна. Зураг төсөл гүйцэтгэхтэй холбоотой тусгай зөвшөөрлүүд огт ороогүй байна. Зургийн тусгай зөвшөөрлүүд шаардлагагүй юу?

Хариулт: Тендерийн сонгон шалгаруулалтын шатанд Шаардахгүй.

7. Ажил гүйцэтгэхэд шаардагдах үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалтыг V бүлгийн Маягт-9-ийн дагуу гаргаж ирүүлнэ гэсэн байна. Маягт-9 гэж байхгүй харин тоног төхөөрөмжийн жагсаалтыг Маягт-3 гэж оруулсан байна. Маягтын дугаар андуурагдсан уу?

Хариулт: Тендерийн баримт бичгийн 5-р бүлэгт заасан тендерийн жишиг маягтуудад нийцүүлэн үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээллийг маягт 3-ын дагуу ирүүлнэ.

8. Маягт-7 тендерийн материал дээр байхгүй байна. Үүнийг хүний нөөцийн мэдээлэлийн маягт-2-ийн дагуу бэлгэх үү?

Хариулт: Тендерийн баримт бичгийн 5-р бүлэгт заасан тендерийн жишиг маягтуудад нийцүүлэн хүний нөөцийн мэдээлэлийг маягт 2-ын дагуу ирүүлнэ.

9. Санал болгож буй ажилтаны жишиг намтар (CV)-г Маягт-8-ийн дагуу бөглөж ирүүлнэ гэсэн байна. Тендерийн материал дээр Маягт-8 гэж огт байхгүй байна. Өөрсдийн маягтын дагуу хүргүүлж болох эсэх?

Хариулт: Болно.

Ажлын даалгавар, зураг төслөөс тодруулах зүйлс

1. Ажил гүйцэтгэж дуусах хугацааг хэрхэн төлөвлөж байгаа вэ?

Хариулт: Төсөл арга хэмжээний барилга угсралтын ажлыг 2026 оны 09 дүгээр сард багтаан улсын комисс ажиллуулан, ашиглалтад оруулсан байна.

2. Төслийн ерөнхий төлөвлөлт, эскиз зургууд холбогдох байгууллагаар батлагдаж Архитектор төлөвлөлтийн даалгавар авсан эсэх. Бусад төрийн байгууллагуудаар зураг хянагдсан эсэх

Хариулт: УРЬДЧИЛСАН ЗУРАГ төслийн ажлын зургийг тендерт тусган оруулсан. Газрын асуудал шийдэгдэхэд Архитектор төлөвлөлтийн даалгавар батлагдан гүйцэтгэгч компани ажлын НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ, төсвийг боловсруулж эрх бүхий байгууллагаар баталгаажуулан магадлалын ерөнхий дүгнэлт гаргуулна.

3. Хэрэв ажлын зураг төслийг холбогдох байгууллагуудаар хянуулж батлуулаагүй байгаа бол энэ ажил маш их хугацаа шаардана. Тэгэхээр тендерийн баримт бичигт энэ хугацааг тодорхой сайн оруулах.

Хариулт: Төсөл арга хэмжээний барилга угсралтын ажлыг 2026 оны 09 дүгээр сард багтаан улсын комисс ажиллуулан, ашиглалтад оруулсан байна.

4. Зураг төсөлд WNS14-1.6/130/70-Q гэсэн маркийн Хятад зуух төлөвлөсөн байна. Энэ зуухнаас өөр улсад үйлдвэрлэгдсэн зуух төлөвлөх боломжтой юу? Эсвэл зургийн дагуу байх уу?

Хариулт: Ажлын даалгаварт шаардсан стандарт, техникийн үзүүлэлтийг хангасан зуух байна.

5. Ажлын даалгаварын 6-р бүлэг Архитектор зураг төслийн нөхцөл гэсэн хэсэг дээр уур халаагуурын нэгдүгээр үеээс уур авч ашиглана гэсэн байна. Энэ төв дээр зөвхөн усан халаалтын зуух ашиглана гэж ойлгож байгаа, уурын бойлер бас суурилуулах шаардлагатай юу? Уурыг юунд хэрэглэх вэ?

Хариулт: Хийн зуухны яндан хоолойгоор гарч буй өндөр параметртэй утааны хийгээр зуухны усыг урьдчилсан ажлын температуртай болтол халаах зорилгоор дахин ашиглах юм. Тухайн төхөөрөмж нь уурын бойлер биш бөгөөд техникийн даалгаварт хий, уур усны төхөөрөмж дээр нэмэлт санал ирүүлж болно.

6. DM-tsetserleg-1 зураг дээр зуухны зарцуулалтыг байгалийн хийгээр тооцсон байна. Байгалийн хийн зуухаар тооцож зургаа зурсан юм уу?

Хариулт: Энэ төслийн хувьд эхний шатанд шингэрүүлсэн нефтийн хий (LPG) ашиглана. Цаашид байгалийн хийн нөөц тогтоогдож, ашиглалтын үйл ажиллагаанд шилжсэн тохиолдолд 2 төрлийн хий ашиглах боломжтой байхаар зуухны сонголтыг хийх нь зүйтэй.

7. Зууханд ашиглах хийн нөөц 3 хоногоос багагүй гэсэн. Зураг дээр 6 ширхэг хадгалах сав зурсан байна. 1 савны багтаамж хэд вэ? Хэдэн м³-ийн багтаамжтай агуулах вэ? Энэ хэмжээ багтаамжууд мэдэгдэхгүй байна. Хэрэв 6 ширхэг савтай агуулах төлөвлөж байгаа тохиолдолд хамгийн багадаа 1 савны багтаамж 200 м³ байх ёстой. Энэ тохиолдолд тухайн савыг тээвэрлэж авчрах асуудал нэлээд хүндрэлтэй болно. Төрөөс энэ савны тээврийн асуудал дээр тусламж үзүүлэх эсэх.

Хариулт: Тендерт оролцогч компани хийн станцын 3 хоногийн нөөцийг харгалзан төлөвлөлт хийж техникийн саналаа ирүүлэх бөгөөд зай, талбайг харгалзан үзнэ.